210601	Багаж, техник, хэрэгсэл	54,669,400.00	54,669,400.00	52,079,400.00	0
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	0
210604	Урсгал засвар	37,345,700.00	35,845,350.00	31,965,350.00	0
2107	Томилолт, зочны зардал	8,242,000.00	8,226,400.00	7,190,400.00	0
210702	Дотоод албан томилолт	8,242,000.00	8,226,400.00	7,190,400.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,911,400.00	7,965,715.00	7,165,715.00	31,071,924.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,760,800.00	4,290,900.00	3,490,900.00	31,071,924.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	638,300.00	324,000.00	324,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,180,000.00	1,180,000.00	1,180,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,598,000.00	1,538,713.00	1,538,713.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	74,000.00	8,000.00	8,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	480,000.00	480,000.00	0
210807	Газрын төлбөр	180,300.00	144,102.00	144,102.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,076,400.00	139,581,940.00	136,784,640.00	16,637,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,275,300.00	129,780,840.00	128,383,540.00	16,637,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,801,100.00	9,801,100.00	8,401,100.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,887,200.00	98,886,700.00	20,606,000.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,887,200.00	98,886,700.00	20,606,000.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,690,000.00	12,690,000.00	12,690,000.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	76,280,700.00	76,280,700.00		0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,916,500.00	9,916,000.00	7,916,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,049,007,700.00	431,406,500.00	431,406,500.00	82,990,000.00
220001	Барилга байгууламж	569,700,000.00	51,948,500.00	51,948,500.00	0
223001	Бусад хөрөнгө	479,307,700.00	379,458,000.00	379,458,000.00	82,990,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	138,000,000.00	51,296,400.00	51,296,400.00	0
230001	Эргэж төлөгдөх зээл	138,000,000.00	51,296,400.00	51,296,400.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,742,820,000.00	5,048,418,397.00	3,167,679,710.00	-200,254,813.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,159,476,900.00	3,159,476,900.00	2,324,790,700.00	-1,001,208,400.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,159,476,900.00	3,159,476,900.00	1,323,582,300.00	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,972,660,100.00	1,599,660,107.00	212,552,807.00	1,142,008,400.00
320001	Орон нутгийн төсвөөс	1,760,107,300.00	1,387,107,300.00	0	1,009,508,400.00
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	212,552,800.00	212,552,807.00	212,552,807.00	132,500,000.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,828,100.00	77,919,290.00	77,919,290.00	0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	75,828,100.00	77,919,290.00	77,919,290.00	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	534,854,900.00	211,362,100.00	552,416,913.00	-341,054,813.00

Бат-Өлзий сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,800,000.00	161,662,201.00	161,662,201.00	0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000,000.00	49,699,899.00	49,699,899.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	341,054,900.00		341,054,813.00	-341,054,813.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	203,209,161.21	0	164,522,869.65
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	306,647,454.21	0	250,049,563.65
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,771.00	2,856.00	0	2,856.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7	0	7
610001	Төсвийн байгууллага	7	7	0	7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	243	243	0	243
620001	Удирдах ажилтан	14	14	0	14
620002	Гүйцэтгэх ажилтан	163	169	0	169
620003	Үйлчлэх ажилтан	65	60	0	60
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,278.00	2,363.00	0	2,363.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,615.00	1,700.00	0	1,700.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,615.00	1,700.00	0	1,700.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	663	663	0	663
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	663	663	0	663
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	243	243	0	243
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	0	11
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3	3	0	3
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	26	26	0	26
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	192	192	0	192
650010	Гэрээт ажилтан	3	3	0	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,321,047.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,331,047.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410,572,147.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,593,757.00
210102	Нэмэгдэл	74,593,757.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,889,243.00
210201	Тэтгэврийн даатгал	9,889,243.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,585,123.00
210401	Бичиг хэрэг	3,351,231.00
210402	Тээвэр, шатахуун	6,916,599.00
210404	Ном, хэвлэл	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,317,293.00
2105	Нормативт зардал	247,494,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,091,900.00
210502	Хоол, хүнс	29,402,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,036,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,036,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,264,000.00
210702	Дотоод албан томилолт	1,264,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,071,924.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,071,924.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,637,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,637,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,758,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,758,900.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тат аас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,758,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,990,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	82,990,000.00
223001	Бусад хөрөнгө	82,990,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	545,321,047.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	545,321,047.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,352,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,294,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	122,216,447.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	346,458,600.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бат-Өлзий сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.09-нөөс 2022.03.14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.07-ны өдрийн 1/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 7 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 11 тайлан нэгтгэгджээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Бат-Өлзий сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бат-Өлзий сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 8 тэрбум 473.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 84.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 63.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.


3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 240.9 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	365.9	606.8	240.9
31211	Төрийн сангийн харилцах	365.9	606.8	240.9

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.



Created with Datawrapper

3.5.2 Авлага

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
33	АВЛАГА	344.1	513.1	169	100
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3.4	3	-0.4	0.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6.3		-6.3	
33400	Зээлийн хүүгийн авлага	6.1	3.8	-2.3	0.74
3351	Байгууллагаас авах авлага	54.6	333.2	278.6	64.94
3352	Хувь хүмүүсээс авах авлага	273.6	173	-100.6	33.72

Тайлант оны нийт авлагын 64.9 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Энэ нь сумын ЭМТ-ийн ЭМД-аас авах авлага байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 154.5 сая төгрөг нь СХСангаас олгосон зээлийн авлага, 18.5 сая төгрөг нь эрсдэлээс хамгаалах сангаас малчдад олгосон өвс тэжээлийн авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 184.6 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
35	БАРАА МАТЕРИАЛ	302.7	487.3	184.6	100
351	Түүхий эд материал	98.5	241.2	142.7	49.5
354	Хангамжийн материал	204.2	246	41.8	50.5
36	НӨӨЦИЙН БАРАА	8.5	8.5	0	

Тайлант онд бараа материалын үлдэгдэл ЭМТөвд 153.2 сая төгрөгөөр өссөн нь ковидын эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эм боох материал, тусгай зориулалттай материалын үлдэгдэл эрс нэмэгдсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1 тэрбум 145.2 сая төгрөгөөр өссөн байна.

Код	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	13,478.90
2	Нэмэгдсэн	1,699.10
201	Худалдан авсан	189.00
202	Хандиваар	10.60
203	Шилжүүлэн авсан	2.20
205	Бусад	1,384.30
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	112.90
3	Хасагдсан	554.00
302	Акталсан	344.10
303	Шилжүүлсэн	9.70
306	Дахин үнэлгээний хорогдол	200.10
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	14,624.10

Бат-Өлзий сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 1 тэрбум 699.1 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 189.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1 тэрбум 510.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 344.1 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 9.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 200.1 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас хассан байна.

Тайлант онд сумын хэмжээнд УТХО-аар 727.7 сая төгрөгийн гүүрийг барьж ашиглалтад оруулсан, 421.9 сая төгрөгөөр барилга байгууламжийн их засвар хийгдсэн, 152.4 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл, 250.5 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж нэмж бэлтгэсэн байна.

3.5.5 Өр төлбөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13.7	363.2	349.5	100
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13.7	363.2	349.5	100
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.15	155.8	155.65	42.9
41361	Байгууллагад төлөх өглөг	13.5	207.4	193.9	57.1
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.05	0.04	-0.01	0.0

Тайлант онд өр төлбөр 349.5 сая төгрөгөөр өссөн нь ЭМТөв ажилчдын цалинд 155.8 сая төгрөгийн өртэй, байгууллагад 175.7 сая төгрөгийн эм болон бараа материалын өртэй гарсантай холбоотой байна. Мөн ЗДТГ 25.1 сая төгрөг, ИТХ 3.3 сая төгрөг, ЭХСан 2.6 сая төгрөг, Соёлын төв 0.6 сая төгрөгийн өртэй гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 3/14 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 1 тэрбум 27.5 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 761.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 265.8 сая төгрөг буюу 25.9 хувиар биелээгүй байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	24,000	31,221	7,221	130.1
2	Хөрөнгийн орлого	101,517	122,342	20,825	120.5
3	Хөрөнгө борлуулсны орлого	1,600	3,040	1,440	190.0
4	Бууны албан татвар	4,575	3,786	(789)	82.8
5	Улсын тэмдэгийн хураамж	6,700	8,184	1,484	122.1
6	Түгээмэл тархцатай АМНАТ	1,300	-	(1,300)	0.0
7	Хог хаягдлын хураамж	12,000	26,548	14,548	221.2
8	Газрын төлбөр	2,804	3,279	476	117.0
9	Ус рашааны нөөц		80	80	
10	Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-	
11	Нохойны татвар		95,063	95,063	
12	Ойн төлбөр	839,000	417,185	(421,815)	49.7
	Татварын орлого	993,496	710,728	(282,768)	71.5
1	Татварын бус/ Хүү, торгуулийн орлого	34,000	50,987	16,987	150.0
	Нийт дүн орлого	1,027,496	761,715	(265,781)	74.1

3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 5 тэрбум 742.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3 тэрбум 159.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 тэрбум 972.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 75.8 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 534.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3 тэрбум 159.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1 тэрбум 599.7 сая төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 77.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 211.4 сая төгрөг, нийт 5 тэрбум 48.4 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 4 тэрбум 328.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 431.4 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 51.3 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 98.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 545.3 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 410.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 83.0 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 49.0 сая төгрөг зарцуулж 2.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бат-Өлзий сумын Төрийн сан нь 2021 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар хөрөнгө бүртгэлд тусгаагүй 24.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Хөрөнгийг бүртгэж зөрчлийг арилгасан тухай биелэлтийг 2021.06.04-ний өдрийн 1/202 тоот албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлсэн.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Бат-Өлзий сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 9 байгууллагын 3 байгууллагад дүгнэлт гаргаж, /Хүн эмнэлэг, ЕБС, Соёлын төв/ 6 байгууллагыг түүвэрт хамруулсан./ ЗДТГ, ИТХ, 1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 117.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 48.7 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 68.7 сая төгрөгийн зөрчилд 27.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, 41.1 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хүргүүлсэн.

-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 1 дүгээр цэцэрлэг 1.0 сая төгрөгөөр ажилчдад дүрэмт хувцас бэлтгэсэн, ЗДТГазар 3.0 сая төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан.

- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 85.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнд:*

ЗДТГазарт- Үнэ төлбөргүй авсан 44.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тодруулга тайланд худалдан авснаар тайлагнаснаас санхүүгийн тайлангийн уялдаа зөрсөн, төсвийн бусад байгууллагад 21.6 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авч өгч шууд зардалд бичсэн. Мөнгөн гүйлгээний тайланд бусад бараа үйлчилгээний зардал, багаж техник хэрэгслийн зардлыг 0.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.

Соёлын төвд- Газар эзэмших эрх, номын фонд дансны 15.1 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн программд тусгасан, тайлант онд худалдан авсан 3.6 сая төгрөгийн 3 программыг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн

- *Дотоод хяналт хариуцлагатай холбоотой 26.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.*

ЭМТөвд- Байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн дотоод хяналт шалгалтын журам баталж мөрдөөгүй,

Соёлын төвд-Номын фондын 2.8 сая төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн тул тоо ширхэг, нэгж үнэ нь тодорхойгүй байгаагаас тооллогод хамрагдсан эсэх, хөрөнгө бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй байна.

ЗДТГазарт- Тайлант оны эцэст байгууллагад төлөх 20.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

ИТХ-д Шатахуунд ковидтой холбоотой зардал гараагүй байтал батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж 3.3 сая төгрөгийн өр үүсгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1.5 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.*

Цэцэрлэгт- Тээвэр шатахууны 1.5 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг тайлагнахдаа жолоочийн тооцооны хуудас НХМаягт ТМ-4 маягтыг бөглөөгүй байна.

ОНХСанд- "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бүртгэж, хариуцуулах тухай" захирамжийн жагсаалтад тайлант онд хийгдэж дууссан томоохон ажлыг оруулаагүй, мөн дуусаагүй ажлыг орлогод авахаар жагсаалтад тусгасан, ажил гүйцэтгэгч талтай шууд гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй

- *Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил*

Бат-Өлзий сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1 дүгээр цэцэрлэг-т Шилэн дансны цахим хуудаст нийт 17 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 4 улирлын хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар байршуулаагүй байна. Мөн сар бүрийн төсөв, гүйцэтгэлийн мэдээг мянгалчигдсан, хэтрэлт, хэмнэлтийн дүн зардал тус бүрээр харуулаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл


(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бат-Өлзий сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР